



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/243

Чингис хот

Зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хилийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дах заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар батлагдсан “Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх “Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар “Хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөл”-ийн Өмнөдэлгэр сумын бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар, Батширээт сумын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, Биндэр сумын бүрэлдэхүүнийг 4 дүгээр хавсралтаар, Дадал сумын бүрэлдэхүүнийг 5 дугаар хавсралтаар, Зөвлөлийн ажиллах журмыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Үндсэн хууль, Хилийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлиг бусад холбогдох эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон батлагдсан журмын дагуу ажиллахыг Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хэнтий аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/12 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

4. Аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл, сумдын Хил хамгаалалтад туслах хүчний салбар зөвлөлд захирамжийг хүргүүлж үүрэг даалгавраар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010082

05 Аймгийн Засаг даргын 2020 оны
... дугаар сарын ... өдрийн ...
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Хэнтий аймгийн Засаг дарга

Зөвлөлийн дарга:

Хилийн 0287 дугаар ангийн захирагч, Хэнтийн хэсгийн Хилийн бүрэн эрхт төлөөлөгч

Нарийн бичгийн дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Хэнтий аймгийн Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Хэнтий аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,

Хэнтий аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга,

Хэнтий аймгийн Цэргийн штабын дарга,

Хэнтий аймгийн Цагдаагийн газрын дарга ,

Тагнуулын ерөнхий газрын Хэнтий аймаг дахь хэлтсийн дарга,

Хэнтий аймгийн Хууль цаазын итгэмжит зөвлөх, ерөнхий прокурор,

Хэнтий аймгийн Онцгой байдлын газрын дарга,

Хэнтий аймгийн "Мэдээл, холбоо сүлжээ" -ний ТӨХК-ны дарга,

Хэнтий аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,

Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын дарга,

Хэнтий аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга,

Хилийн Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал сумдын засаг дарга нар

Аймгийн Засаг даргын 2020 оны
... дугаар сарын ... өдрийн ...
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД
ТУСЛАХ ХҮЧНИЙ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Сумын засаг дарга

Орлогч дарга:

Хилийн 0287 дугаар ангийн штабын ажилтан

Нарийн бичгийн дарга:

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Хилийн 0279 дүгээр салбарын захирагч

Санхүүгийн албаны дарга,

Сумын хэсгийн төлөөлөгч,

Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч,

Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга,

Хилийн багийн Засаг дарга,

Аймгийн Засаг даргын 2020 оны
05 дугаар сарын 13 өдрийн 0/243
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

БАТШИРЭЭТ СУМЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД
ТУСЛАХ ХҮЧНИЙ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Сумын Засаг дарга

Орлогч дарга:

Хилийн 0287 дугаар ангийн штабын ажилтан

Нарийн бичгийн дарга:

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Хилийн 0279 дүгээр салбарын захирагч

Санхүүгийн албаны дарга,

Сумын хэсгийн төлөөлөгч,

Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч,

Мал эмнэлгийн тасгийн дарга,

Онон багийн Засаг дарга

Аймгийн Засаг даргын 2020 оны
...125... дугаар сарын...13...өдрийн...01/12/20...
дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

БИНДЭР СУМЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД
ТУСЛАХ ХҮЧНИЙ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Сумын Засаг дарга

Орлогч дарга:

Хилийн 0287 дугаар ангийн штабын ажилтан

Нарийн бичгийн дарга:

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Хилийн 0239 дүгээр салбарын захирагч

Санхүүгийн албаны дарга,

Сумын цагдаагийн тасгийн дарга,

Биндэр сумын "Биндэр ой" сум дундын ойн ангийн дарга,

Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч,

Мал эмнэлгийн тасгийн дарга,

Баянгол багийн Засаг дарга

Аймгийн Засаг даргын 2020 оны
05 дугаар сарын 13 өдрийн 0/243
дугаар захирамжийн тавдугаар хавсралт

ДАДАЛ СУМЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУСЛАХ ХҮЧНИЙ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга:

Сумын Засаг дарга

Орлогч дарга:

Хилийн 0287 дугаар ангийн штабын ажилтан

Нарийн бичгийн дарга:

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Сумын санхүүгийн албаны дарга

Отрядын дэргэдэх тагнуулын тасгийн дарга,

Сумын хэсгийн төлөөлөгч,

ОББЦГ-ын хамгаалалтын захиргааны дарга,

Дадал сумын шуудан үйлчилгээний салбарын шууданч,

Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч,

Мал эмнэлгийн тасгийн дарга,

Балж багийн Засаг дарга,

Агац багийн Засаг дарга,

ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

1. Улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл нь улсын хил орчмын нутаг дэвсгэрт хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад оролцоно.
2. Улсын хил хамгаалалтад туслах хүчнийг хилийн аймаг, сум, багийн төв, хилийн цэргийн анги, салбар, суурин газар болон шаардлагатай бусад газарт улсын хил хамгаалах байгууллагын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар байгуулна.
3. Хил орчмын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа, 18 нас хүрсэн Монгол Улсын иргэнийг улсын хил хамгаалалтад туслах хүчний гишүүнээр бүртгэхдээ түүний бичгээр гаргасан хүсэлт, улсын хил хамгаалах байгууллагын саналыг үндэслэн аймаг, сумын туслах хүчний зөвлөлөөр хэлэлцэж, Засаг даргын захирамжаар батална.
4. Улсын хил хамгаалалтад туслах хүчнийг аймаг, сумын Засаг дарга, түүний дэргэдэх зөвлөл, улсын хил хамгаалах байгууллага тус тусын бүрэн эрхийн хүрээнд удирдлагаар хангана.
5. Зөвлөлийн дарга нь аймаг, сумын Засаг дарга, түүний орлогч дарга нь хилийн цэргийн ангийн дарга, нарийн бичгийн дарга нь хилийн аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын дарга байна.
6. Зөвлөл нь дараах бүрэн эрхтэй:
 - 6.1. Улсын хил хамгаалах байгууллагын хангалт үйлчилгээнд туслалцаа үзүүлж, Монгол Улсын хилийн хууль тогтоомжийг иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага сахин биелүүлж байгаад хяналт тавих;
 - 6.2. Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахад шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
 - 6.3. Иргэнийг сайн дурын үндсэн дээр улсын хил хамгаалалтад татан оролцуулах;
 - 6.4. Иргэдийг ажил, үйлдвэрлэл, нутаг дэвсгэрийн байрлалаар нь улсын хил хамгаалалтад туслах хүчин болгон зохион байгуулж, хил хамгаалалтад оролцуулах;
 - 6.5. Хилийн аймаг сумын төсөвт улсын хил хамгаалалтад зориулсан нэмэгдэл зардал тусгах;
7. Улсын хил хамгаалах байгууллага, хилийн аймаг, сумын улсын хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл нь хил хамгаалалтад идэвхтэй оролцсон туслах хүчний гишүүнд урамшуулал олгож, шагналд тодорхойлж болно.
8. Зөвлөл нь дараах үүргийг хүлээнэ:
 - 8.1. Нутаг дэвсгэртээ байгаа улсын хил хамгаалах байгууллагын саналыг үндэслэн хил хамгаалалтад туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

8.2. Улсын хил хамгаалах байгууллагатай хамтран туслах хүчнийг хил хамгаалалтад оролцуулах ажлыг зохион байгуулах;

8.3. Улсын хил хамгаалалтад төсөвлөсөн зардлын зарцуулалтад хяналт тавих;

8.4. Улсын хилийн зурвас, бүсэд улсын хил хамгаалах байгууллагын зохих зөвшөөрөлтэйгөөр ажил, үйлдвэрлэл эрхэлж байгаа туслах хүчний гишүүдийг оршин суугаа газраар нь хил хамгаалалтад оролцуулах ажлыг зохион байгуулах;

8.5. Улсын хилийн болон хил орчмын дэглэмийг санаатай буюу давтан зөрчсөн Монгол Улсын иргэнийг хуулийн байгууллагад шилжүүлэх саналыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

8.6. Улсын хил хамгаалалтад идэвх зүтгэлтэй ажилласан, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг удаа дараа илрүүлсэн туслах хүчний гишүүнийг шагнаж урамшуулах, шагналд тодорхойлох, зөрчил гаргасан гишүүнийг туслах хүчний бүрэлдэхүүнээс хасах арга хэмжээ авах;